



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/291

Номгон

Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн  
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны A/273 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 40, 41 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг нэг шат буурсантай холбогдуулан коронавируст халдвартархах эрсдэлээс иргэд, олон нийтийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 00:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 24:00 хүртэл гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан үйл ажиллагаа явуулах зөвшөөрөгдсөн салбар, байгууллагуудын жагсаалтыг нэгдүгээр, хязгаарлалт тогтоосон байгууллага, аж ахуй нэгжүүдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх хугацаанд иргэдийг коронавируст халдвартын эсрэг дархлаажуулалтад хуваарийн дагуу бүрэн хамруулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-д;

4.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөгдсөн салбар байгууллагуудын үйл ажиллагааг шаардлага хангасан тохиолдолд үйл ажиллагааг нь нээж, халдварт хамгааллын дэглэм сахиулж, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж);

5.Тус аймаг руу орох, гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, тус аймгаас Улаанбаатар хот руу эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах ажлаар зорчих иргэдийг нийслэлийн


2.

Онцгой комиссын зөвшөөрлөөр, Улаанбаатар хот болон бусад аймгуудаас тус аймагт эрүүл мэнд, буяны ажил, хүнс, шатахуун, өвс тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах ажлаар зорчих иргэдийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр, аймаг дотор (өөрийн аймгийн сум хооронд) зорчих иргэдийг сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр тус тус нэвтрүүлэх, шаардлагагүй тохиолдолд Улаанбаатар хот болон халдвартын тархалтын "Шар", "Улбар шар", "Улаан" түвшин бүхий аймгуудаас иргэдийг татан авахгүй байхыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т;

6.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб, сумдын Онцгой комиссын Шуурхай штаб болон хяналтын постыг дахин шинэчлэн байгуулж, үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг ханггуулж ажиллахыг Онцгой комиссын нарийн бичгийн дарга (дэд хурандаа Э.Батбаяр)-д;

7.Архи согтууруулах ундааг нутаг дэвсгэрийн хэмжээнд худалдан борлуулахгүй байхыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар  
сарын 07-ны өдрийн А/291 дүгээр захирамжийн  
1 дүгээр хавсралт

**ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨӨДСӨН САЛБАР  
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ**

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж;
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага;
3. Шатахуун, түлшний худалдаа, тээвэрлэлт;
- 4.Хүнсний худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт (хүнсний дэлгүүрүүд 10:00-20:00, барааны зах худалдааны төвүүд 11:00-17:00 цагийн хооронд);
- 5.Ариутгал, халдвартгүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, тээвэрлэлт;
6. Банкууд цахимаар болон ажлын тусгай горимоор халдварт хамгааллын дэглэм сахиж ажлын өдрүүдэд;
7. Харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, шуудан илгээмж;
8. Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, шүүх, прокурор, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг хэвийн горимоор;
9. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа;
- 10.Тусгай зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагаа;
11. Авто засвар болон дугуй засварын үйл ажиллагаа (10:00-20:00 цагийн хооронд);
12. Жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа;
13. Уул уурхайн ээлж солилцох үйл ажиллагаа (Бусад хангамж);
14. Газар тариалангийн үйл ажиллагаа;
15. Барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, тээвэрлэлт,
16. Халуун ус, үсчин халдварт хамгааллын дэглэм сахиж, ажлын тусгай горимоор;
17. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдын хичээлийн давтлага;

2.

18. Буян номын үйл ажиллагаа.

19. Улирлын чанартай ноос, ноолуур бэлтгэх, орон нутгийн үйл ажиллагаа(аймаг доторх хөдөлгөөнийг тухайн сумдын Онцгой комиссын шийдвэрээр);

20. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа.

21. Шалган бүртгэх товchoоны гадна ажиллаж, амьдардаг оршин суугч нар тухайн багийн тодорхойлолттой орох, гарах;

Жич:

- Улаанбаатар хотоос дээрх зөвшөөрөгдсөн салбарын ажиллагааны бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлт, нийлүүлэлт, түгээлтийг өдөр бүрийн 06:00-11:00 цагийн хооронд (Ачаа тээвэр);

- Аймаг доторх хүнсний тээвэр, түгээлт, нийлүүлэлт тусгай зөвшөөрлийн дагуу ажлын тусгай горимоор хэвийн явагдана.

\_\_\_\_\_oOo\_\_\_\_\_

Аймгийн Засаг давгын 2021 оны 05 дугаар  
сарын 07-ны өдрийн А/291 дүгээр захирамжийн  
2 дугаар хавсралт

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООСОН БАЙГУУЛЛАГА,  
АЖ АХҮЙ НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

1. Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, цайллага, хүлээн авалт;
2. Биеийн тамир спортын арга хэмжээ;
3. Цахимаар болон зайнлас зохион байгуулахаас бусад соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаа;
4. Иргэд хөдөлгөөнд оролцохдоо 1 автомашинд 2 хүн, 1 суудал алгасаж суух, хүн хоорондын зайд барьж, халдварт хамгааллын дэглэм сахих;
5. Жагсаал, цуглаан, уралдаан, тэмцээн;
6. Аялал зугаалга, хурим найр;
7. Бүх төрлийн кафе, баар, караоке;
8. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа;
9. Цахим тоглоомын газрууд;
10. Сургалтын төвүүд;
11. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төвүүд;
12. Зочид буудал, дэн буудал;
13. Амралт, жуулчны газар;
14. Сүм хийдийн үйл ажиллагаа;
15. Нийтийн бүжиг, бүжгийн клубүүдийн үйл ажиллагаа;
16. Цахилгаан шатанд 3-аас илүүгүй хүн суух;
17. Айлд зочлох, зочин урих;
18. Иргэн шаардлагагүй тохиолдолд гэрээс гарагчийг байх;
19. Олон нийтийн газар аль болох очихгүй байх;
20. Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах;
21. Аймаг орон нутгаас зохион байгуулж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх.